

WeFriends Aid-н даатгалд хэрхэн элсэх болон эмчилгээний дэмжлэг үзүүлэх тухай

1. WeFriends Aid гэдэг нь?

Солонгост үндэсний эрүүл мэндийн даатгалд хамрагдаж чадаагүй гадаад иргэдэд тул гарч буй эрүүл мэндийн асуудлыг шийдэх үүднээс гишүүнчлэлд хамрагдан мөн түүн члэн гишүүд хоорондоо харилцан туслалцах боломжийг бүрдүүлсэн систем болно.

2. Хамрагдах иргэд болон хэрхэн элсэх

1) Хамрагдах иргэд

Солонгост ирээд 6 сараас дээш хугацаагаар оршин сууж байгаа эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй гадаад иргэд болон тэдний үр хүүхэд, дүрвэгсэд мөн харья алалгүй иргэд хамрагдах боломжтой.

2) Гадаад иргэд WeFriends Aid –н даатгалд элсэхийг хүсвэл?

(1) Та өөрийн ажиллаж амьдарч буй газартай хамгийн ойр орших хамтарч ажиллагч дэмжих (зөвлөгөө өгөх) төв дээр очих ба дараахь бичиг баримтыг бэлтэнэ.

① Паспортын хуулбар

② Цээж зураг (паспортын формат) 2 хувь

③ Гишүүний элсэлтийн хураамж 10,000 вон + эхний сарын хураамж 10,000 вон (үүнээс хойш сар бүр гишүүний хураамж болох 10,000 вонг төлөх болно)

(2) Гишүүний хүүхэд

Нэг гэр бүлийн эхнэр нөхөр тус тусдаа WeFriends Aid-н даатгалд элсэх бөгөөд н асанд хүрсэн нэг хүн 13 наснаас доош 2 хүртэл хүүхдийг асрамжиндаа авч болохор тогтоосон байдаг. Тиймээс сарын даатгалын хураамж нь 1 хүүхэдтэй бол 10,000 вон, 2 хүүхэдтэй бол 15,000 вон болно.

3. WeFriends Aid даатгалыг хэрхэн ашиглах талаарх танилцуулга

1) Гишүүний хураамж төлөх

Та анх даатгалд элссэн зөвлөгөө өгөх дэмжих төвөөр дамжуулан сар бүрийн гишүүний хураамжаа төлөх ба үүний дараа эмчилгээний картан дээр тамга даруулна. Гишүүний хураамжийг 3 сараас дээш хугацаанд төлөөгүй тохиолдолд эмчилгээний тусламж авах боломжгүй.

2) Эмнэлгийн байгууллагаар хэрхэн үйлчлүүлэх

Та бүхний авсан гадаад иргэдийн эмчилгээний карт нь зөвхөн WeFriedns Aid-тай хамтарч ажилладаг эмнэлэгт л хэрэгжих бөгөөд анх даатгалд элссэн зөвлөгөө өгөх дэмжих төврүү утсаар холбогдож, таньтай хамгийн ойр орших эмнэлэг, эмнэлгийн байгууллагийн талаарх мэдээлэл авна уу.

3) Эмчилгээний төлбөрийн хүсэлт хэрхэн гаргах тухай

Эмчилгээний төлбөрийн дэмжлэг авахдаа гишүүн эхлээд эмнэлгийн төлбөрөө өөрөө төлсний дараа зөвлөгөө өгөх дэмжих төвөөр дамжуулан хүсэлт гаргуулна. Эмчилгээний төлбөр төлсөн баримт 1-ийг эх хувиар, оношилгоо (эмчийн магадлагаа) 1 хувь, WeFriedns Aid-н гишүүний карт мөн паспортын хуулбарыг бүрдүүлэн анх элссэн дэмжих төвөөр дамжуулан хүсэлтээ гаргана.

4) WeFriedns Aid-н даатгалд элсэн орсноор та ямар хөнгөлөлтийг авах боломжтой вэ?

(1) WeFriedns Aid-н даатгалд элсэн орсны дараа

① Хамтарч ажилладаг эмнэлгийн байгууллагаас эрүүл мэндийн даатгалаар 100% хөнгөлөлт авах боломжтой. Гагцхүү даатгалд ордоггүй (төлбөртэй эмчилгээнүүд)-эмчлгээ болон шинжилгээний зардлын хувьд дэмжлэг авах боломжгүй болно.

(2) WeFriedns Aid-н даатгалд элсээд 3 сар болсоны дараа

① Хамтарч ажилладаг эмнэлгийн байгууллагад амбулаторын үзлэгт орохдоо өдөрт 100,000 воноос дээш зардал(эмний мөнгө ороод) гарах тохиолдолд нийт гарсан зардлын 40%-ийг буцаан олгоно. Жилд 700 мянган вон хүртэл.

② Хамтарч ажилладаг эмнэлгийн байгууллагад хэвтэж эмчлүүлэх, мэс засал хийлгэх тохиолдолд дээд тал нь 1,000,000 вон дотор эмчилгээний зардлаас 50%-тай тэнцэх дэмжлэг үзүүлэх бөгөөд жилд 2 хүртэл удаа байж болно. (Дээд зэрэглэлийн өрөөний төлбөр гэх мэт даатгалд ордоггүй төрлүүд хамаарагдахгүй)

③ Хамтарч ажилладаг эмнэлэгт тухайн гишүүн эмчилгээ хийлгэх явцдаа нас барсан тохиолдолд тусалж чадах хамгийн дээд хэмжээгээр эмнэлгийн төлбөрийн тусламжийг WeFriedns Aid-ээс олгоно. Энэ үед тусламж хүсэгчийн төлөөлөгч нь нас барсан гишүүний хамгийн сүүлд үйлчлүүлж байсан дэмжих төвөөр дамжуулан эмчилгээний тусламжийн хүсэлт гаргуулах бөгөөд анкетан дээр тухайн зөвлөгөө өгөх дэмжих төвийн тамга заавал дарагдсан байх ёстой.

(3) Яаралтай эмчилгээний тусламж, нэн түрүүнд олгогдох тохиолдлууд

① Дотрын архаг хурц өвчинөө эмчлүүлэх шаардлагтай өвчтөн (яаралтай тусламж)

② Яаралтай хагалгаанд орох шаардлагтай өвчтөн

③ 72 цагийн дотор мэс засал болон яаралтай эмчилгээ хийлгэх шаардлагтай өвчтөн

(4) Жилд олгох эмчилгээний тусламжийн хэмжээ

Гишүүнд олгох эмчилгээний тусламжийн хамгийн дээд хэмжээ нэг удаа 1,000,000 вон бөгөөд жилд 2 удаа туслах боломжтой. Энэ нь гадны сангийн дэмжлэгтэй үе

д олгогдоно.

5) Эмчилгээний тусламж олгохгүй тохиолдлууд

- (1) Өргөдөл гаргасан өдрөөс эхлэн 6 сарын өмнөх эмчилгээний үед
- (2) Аж үйлдвэрлэлийн осол
- (3) Гэмтэл ба авто тээврийн осол (зодоон зохионоос үүдэлтэй бэртэл, өөрийгөө гэм тээх)
- (4) Функциональ асуудал биш тохиолдолууд, гоо сайханы мэс засал, арьсны эмгэгийн эмчилгээ, шүдний эмчилгээ
- (5) Хорт хавдрын мэс ажилбар болон хавдрын эсрэг химийн эмчилгээ, бөөрний диализ, эрхтэн шилжүүлэн суулгах, үргүйдлийн эмчилгээ гэх мэт тасралтгүй эмчилгээ шаарддаг архаг өвчний хувьд
- (6) Улсын хяналтанд байдаг сүрьеэ, уяман өвчин, ДОХ гэх мэт
- (7) Төрөхөд туслах эмчилгээний зардал
- (8) Солонгост эмчилгээний зорилгоор орж ирсэн гадаад иргэд



희망의
친구들™ (사)한국이주민건강협회 WeFriends Aid

03735 서울시 서대문구 통일로 9길 12 2층

전화 : (02)3147-0516~8

전자우편 : we@wefriends.org

팩스 : (02)3147-0519

홈페이지 : <http://www.wefriends.org>